



**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 07-ны өдөр

Дугаар 44, А/2024

Улаанбаатар хот

**Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл  
мэндийн тодорхойлолт гаргах  
журам батлах тухай**

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, 31.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргах журам”-ыг нэгдүгээр, “Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн үзлэгийн маяг”-ыг хоёрдугаар, “Шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болох эрүүл мэндийн шалтгааныг тогтоох, эрүүл мэндийн үзлэгийн маяг”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт даалгасугай.


3. Тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргах журам батлах тухай” 41/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЭНХБОЛД



## ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, 31.2 дахь хэсэгт заасны дагуу шүүгчид нэр дэвшигч /цаашид “нэр дэвшигч” гэх/ шүүгчийн албан тушаалд томилогдоход харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүйг нотолсон эрүүл мэндийн тодорхойлолт гаргахтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Эмч, эмнэлгийн ажилтан нь шүүгчид нэр дэвшигчийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргахдаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г чанд мөрдөж ажиллана.

1.3. Нэр дэвшигчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, үнэн зөв тодорхойлох, шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

### Хоёр. Эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тодорхойлолт гаргах

2.1. Шүүхийн ерөнхий зөвлөл нэр дэвшигч эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулахад шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.

2.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн сайтад байршуулсан маягтын дагуу нэр дэвшигч нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана. Эрүүл мэндийн үзлэгийн маягтын дээд хэсгийг голлуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн тэмдгийг дарсан байна.

2.3. Нэр дэвшигч шүүгчийн сонгон шалгаруулах тухай зард заасан материал хүлээн авах хугацааны дотор болон шүүгчээр ажиллах хугацаанд эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулах шаардлага гарсан шүүгч нь харьяалах нутаг дэвсгэрийн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагад үзлэгт хамрагдаж, эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулна.

2.4. Орон нутгийн төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага нь нэр дэвшигчид болон эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулах шаардлага гарсан шүүгчийн сэтгэц, чих, хамар, хоолой, мэдрэлийн байдалд үзлэг, шинжилгээг хийж үзлэгийн тайланг холбогдох журмын дагуу гаргана.

2.5. “Шүүгчээр томилон ажиллуулахад харшлах өвчний жагсаалт”-аас бусад өвчний үед 58.1.3 дахь заалтыг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.6. Нэр дэвшигч болон эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулах шаардлага гарсан шүүгчийн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дараах ажиллагаагаар гаргана.

2.6.1.сэтгэцийн мэргэжлийн зэрэг цолтой, ажлын туршлагатай 3 ба түүнээс дээш сэтгэцийн эмчийн бүрэлдэхүүнтэй комисс тухайн үеийн сэтгэцийн байдлыг үзэж, үнэлэн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг гаргана.

2.6.2.сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах комиссыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын тушаалаар томилно.

2.6.3.сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, ярилцлага, шаардлагатай тохиолдолд сэтгэц эмгэг судлалын шинжилгээний аргуудыг ашиглан оношилж, тодорхойлолт гаргана.

2.7.Эрүүл мэндийн тодорхойлолт гаргаж буй эмч, эмнэлгийн ажилтнууд маягтыг бүрэн бөглөж, үзлэг, шинжилгээ бүрийн дүнг баталгаажуулна.

2.8.Эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан эцсийн дүгнэлт гаргаж, маяганд гарын үсэг зурж, өөрийн гарын үсэг болон нэр дэвшигчийн зургийг эрүүл мэндийн байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна.

2.9.Эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад мөрдөж буй тарифын дагуу төлнө.

2.10.Эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулагч нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, эрүүл мэндийн хуурамч тодорхойлолт гаргуулсан, эсхүл албан ёсоор гарын үсэг зурж баталгаажуулах ёстой эмнэлгийн удирдах ажилтнаас өөр албан тушаалтны гарын үсэг зурадсан тохиолдолд эрүүл мэндийн тодорхойлолтыг хүчингүйд тооцно.

### **Гурав.Хариуцлага**

3.1.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---



Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга,  
Эрүүл мэндийн сайдын 2022 оны 74  
дугаар хамтарсан тушаалын 3 дугаар  
хавсралт

**ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ БОЛОХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШАЛТГААНЫГ ТОГТООХ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ҮЗЛЭГИЙН МАЯГТ**

Зураг

3x4

- А.Шүүгчийн эцэг /эх/-ийн нэр:.....Өөрийн нэр:.....  
 Б.Нас:.....Хүйс:....., Регистрийн дугаар.....  
 В.Ажиллаж буй шүүхийн нэр:.....  
 Г.Үзлэг хийсэн эмнэлгийн нэр:.....  
 Д.Үзлэг, шинжилгээний дүн:...../тэнцэнэ, тэнцэхгүй/

№	Үзүүлэлт	Үзлэгийн хариу	Үзлэг хийсэн огноо	Үзлэг хийсэн эмчийн гарыг үсэг, хувийн тамга
1	Сэтгэц			
2	Мэдрэл			
3	Чих, хамар, хоолой			

Дүгнэлт:.....

Байгууллагын дарга: ..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/  
 Тамга

Байгууллагын дарга: ..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/  
 /тамга/

Комиссын гишүүд: ..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/

..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/

..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/

.....он.....сар.....өдөр